**ХЭНТИЙ АЙМАГ**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 04 сарын 28 өдөр Дугаар Б/21 Чингис хот

Ч.Болормаад сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1, 131.1.2 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 10.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архив, бичиг хэргийн эрхлэгч Ч.Болормаа нь удаа дараа аймгийн Засаг даргын захирамжийн үг, үсгийн алдааг хянаагүй албажуулж гаргасан нь төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй зөрчлийг гаргасан тул албан тушаалын цалингийн хэмжээг 1 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Ч.Болормаад ногдуулсан сахилгын шийтгэлийг цалингаас тооцож суутгахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ч.Болормаад үүрэг болгосугай.

ДАРГА Ж.ГАНБААТАР

№

| САХИЛГЫН ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭГДЭХ ХУУДАС | | | |
|---|---|---|---|
| 1. | Зөрчил гаргагчийн нэр, албан тушаал | Ц.Болормаа<br>АЗДТГ-ын архив, бичиг хэргийн эрхлэгч | |
| 2. | Зөрчлийн мэдээлэл | Аймгийн З.[illegible] 2017.04.?-ний өдрийн А/157, 2017.04.25-ний А/167 дугаартай захирамжийн үг, үсгийн алдаа хянаагүй албан хууль гаргасан нь ТАХХ-н үндсэн зорилт, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд зөрчил түг түг гаргасан. | |
| 3. | Шалгаж тогтоосон эсэх | Зөрчил гаргагчаас авсан тайлбар, албан хууль гаргасан захирамжийн үндсэн хувь бичгээр тогтоогдож байгаа. | |
| 4. | Зөрчил гаргагчийн тайлбар | Архив, бичиг хэргийн эрхлэгч Ц.Болормаа нь гаргасан алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрч бичгээр тайлбар гаргаж өгсөн. Тайлбарыг нотлох баримтанд хавсаргав. | Ц.Болормаа<br>Гарын үс |
| 5. | Хэлтсийн даргын санал | Хөдөлмөрийн тухай хуулийн 131-р зүйлийн 131.1.2 дахь хэсгийн заалтаар үндсэн цалинг 1 сар хүртэл хугацаагаар 20 хувиар бууруулах саналтай байна. | Д.Дот.Октябр<br>Гарын үсэг<br>[signature] |
| 6. | Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэр | 1 сарын цалин 20%. бууруулах | [signature]<br>Гарын үсэг |
| 7. | Шийдвэрийн огноо, дугаар | | |

Хууль эрх зүйн хэлтсийн даргад
тайлбар гаргах учир нь:

АЗДТГ-ын Архив, бичиг хэргийн эрхлэгч Ц. Болормаа миний бие 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан аймгийн Засаг даргын А/157, А/167 дугаар захирамжийг анхны ачааллаас болж үг үсэг болон найруулга зүйн алдааг хянан гаргалгүйгээр алдаатай захирамж гаргасан байна. Ийнд гаргасан зөрчил дутагдлыг хүлээж зөвшөөрч цаашид албан хэрэг хөтлөлтөндөө анхаарч төлөөр эрх үүрэг байгаа албан бичигт хяналт сайн тавьж дахин алдаа дутагдал гаргахгүй ажиллах болохоо мэдэгдье.

Архив бичиг хэргийн
эрхлэгч Ц. Болормаа
2017. 04. 27